

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2006 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**ЭРДЭМТЭН, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийг шинэчлэн байгуулсугай.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийн ажиллах журмыг 1 дүгээр хавсралтаар, бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 88 дугаар зарлигийг хүчингүйд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**